



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 9/16

Тавин

Г Хурдан морины уралдаанч хүүхдийн
амь нас, эрүүл мэндийг хамгаалах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, Засгийн газрын 2019 оны “Хурдан морины уралдааны талаар авах арга хэмжээний тухай” 57 дугаар тогтоол, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2016 оны А/36 тоот тушаалаар батлагдсан “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ийн хавсралт 3 дугаар зүйлийн 3.10.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Хурдан морины уралдаанч хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор сумын хэмжээнд жил бүрийн 11 дүгээр сарын 01-нээс 05 дугаар сарын 01-нийг хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, сунгаан, үсэргээнд хүүхдээр хурдан морь унуулахыг хориглосугай.

2.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сум, тосгоны Хамтарсан баг, Цагдаагийн тасагт үүрэг болгосугай.

3.Холбогдох хууль тогтоомжийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад мэдээлж, сурталчлан ажиллахыг Нийгмийн бодлогын мэргэжилтэн (С.Солонго)-д даалгасугай.



Б.СЭРГЭЛЭН